



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/271

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2 дахь хэсгийн 2.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Алтан төлийн эзнээр шалгарсан Д.Намсрайжавд өргөмжлөл хийлгэхэд 175,000 төгрөг, аймгийн сувинер авахад 10,000,000 төгрөг, Монголын Залуучуудын холбооны шагналын зардалд 926,000 төгрөг, Эрүүл мэндийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг аймагт ажиллах зардалд 1,964,000 төгрөг, Германы хамтын ажиллагааны GIZ төслийн хүмүүс аймагт ажиллах зардалд 218,000 төгрөг, АНУ-ын элчин сайдын яамны Олон нийттэй харилцах албаны дарга болон бусад хүмүүс аймагт ажиллах зардалд 418,000 төгрөг, Тусгай хэрэгцээт хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн, сургалт хийх зардал 356,000 төгрөг, Туркийн хамтын ажиллагаа, зохицуулах агентлаг ТИКА-ийн дэд ерөнхийлөгч Үмит Нажи аймагт ажиллах зардалд 2,251,025 төгрөг, Монгол, Орос, Хятадын харилцааны түүхэн дэх Алтайн хязгаар нутаг ном авах зардалд 542,000 төгрөгийг баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулагдах 16,850,025 төгрөг (арван зургаан сая найман зуун тавин мянга хорин тав)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 1420